



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр


Дугаар 14

Улаанбаатар хот

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтэц шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8, 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.2 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 3.8.2 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтцийг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан хоёрдугаар хавсралтад заасан захиргааны алба, нэгжүүд, зарим бүрэлдэхүүн сургуулиудыг татан буулгаж, шинээр байгуулах захиргааны газар, алба, нэгжүүд, бүрэлдэхүүн сургуулиудыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
3. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан зохих хууль, дүрэм, журамд нийцүүлэн, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-д даалгасугай.
4. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиргааны нэгжүүдийн чиг үүргийн уялдаа холбоог хангаж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, их сургуулийн хамт олноос гаргасан саналыг тусгаж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор (Т.Намнан)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтэц батлах тухай” 07 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.




УДИРДАХ ЗӨВЛӨЛ

РЕКТОР

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ

РЕКТОРЫН ЗӨВЛӨЛ



ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 14 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



**Татан буугдах захиргааны алба, нэгж,
бүрэлдэхүүн сургуулиуд**

№		Захиргааны нэгжүүд
1	1	Эрдэм шинжилгээ, технологи эрхэлсэн проректор
2	2	Сургалт, цахим шилжилт эрхэлсэн проректор
3	3	Санхүү, төлөвлөлт эрхэлсэн проректор
4	4	Ректорын ажлын алба (РАА)
5	5	Хүний нөөцийн алба (ХНА)
6	6	Хяналт шинжилгээ, дотоод аудитын алба (ХШДАА)
7	7	Гадаад харилцаа, нийгмийн түншлэлийн алба (ГХНТА)
8	8	Сургалтын бодлого, хөтөлбөрийн алба (СБХА)
9	9	Оюутны хөгжил, соёл, үйлчилгээний алба (ОХСҮА)
10	10	Судалгаа, хөгжүүлэлтийн алба (СХА)
11	11	Ахисан түвшний хөтөлбөрийн алба (АТХА)
12	12	Санхүү, хөрөнгө оруулалтын алба (СХОА)
13	13	Хангамж, үйлчилгээний алба (ХҮА)
14	14	Мэдээллийн технологийн төв (МТТ)
15	15	Инновац, технологи дамжуулалтын төв (ИТДА)
16	16	Эрүүл мэндийн төв (ЭМТ)
		Менежментийн хувьд бие даан ажиллах нэгжүүд
17	1	Инженерийн ахисан түвшний сургууль (ИАТС)
18	2	Нээлттэй боловсролын төв (НБТ)
19	3	Шинжлэх ухаан технологийн төв номын сан (ШУТТНС)
20	4	Хэвлэлийн газар (ХГ)
		Бүрэлдэхүүн сургуулиуд
21	1	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль (БуХС)
22	2	Бизнесийн ахисан түвшний сургууль (БАТС)

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын
20-ны өдрийн 14 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



**Шинээр байгуулагдах захиргааны алба, нэгж,
бүрэлдэхүүн сургуулиуд**

№		Захиргааны нэгжүүд
1	1	Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор
2	2	Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн проректор
3	3	Санхүү, төлөвлөлт эрхэлсэн проректор
4	4	Хөгжлийн бодлого, дижитал шилжилт эрхэлсэн проректор
5	5	Захиргааны удирдлагын газар (ЗУГ)
6	6	Хяналт шинжилгээ, дотоод аудитын алба (ХШДАА)
7	7	Төлөвлөлт, дижитал шилжилтийн алба (ТДША)
8	8	Гадаад харилцааны алба (ГХА)
9	9	Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн алба (ЭШТХА)
10	10	Инновац, бизнес түншлэлийн алба (ИБТА)
11	11	Сургалтын бодлого, зохицуулалтын алба (СБЗА)
12	12	Оюутны үйлчилгээний алба (ОУА)
13	13	Санхүү, хөрөнгө оруулалтын алба (СХОА)
14	14	Барилга байгууламж, дэд бүтцийн алба (ББДБА)
15	15	Мэдээллийн технологийн төв (МТТ)
16	16	Эрүүл мэндийн төв (ЭМТ)
17	17	Ахисан түвшний сургууль (АТС)
		Менежментийн хувьд бие даан ажиллах нэгжүүд
18	1	Нээлттэй боловсролын хүрээлэн (НБХ)
19	2	Шинжлэх ухаан технологийн төв номын сан (ШУТТНС)
20	3	Хэвлэлийн газар (ХГ)
		Шинээр байгуулах бүрэлдэхүүн сургууль
21	1	Менежментийн сургууль (МС)
22	2	Нийгэм, хүмүүнлэгийн сургууль (НХС)
		Оноосон нэр өөрчлөгдөх бүрэлдэхүүн сургууль
23	1	Механик инженер, тээврийн сургууль (МИТС)
24	2	Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургууль (ХХҮДС)
25	3	Эрчим хүчний инженерчлэлийн сургууль (ЭХИС)



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр


Дугаар 15

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.4 дүгээр заалт, Монгол банкнаас зарласан инфляцын түвшин, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг хавсралтаар тогтоон, 2025-2026 оны хичээлийн жилд мөрдсүгэй.

ДАРГА  Д.ГАНТУЛГА

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолын хавсралт



ШУТИС-ИЙН 2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ СУРГАЛТЫН НЭГ КРЕДИТИЙН ҮНЭЛГЭЭ

Д.Д	СУРГУУЛЬ	Хөтөлбөрийн ангилал	нэг кредитийн үнэлгээ төгрөгөөр			
			2024/25 оны хичээлийн жилд шинээр элсэгч	2023/24 оны хичээлийн жилд элссэн оюутан	2022/23 оны хичээлийн жилд элссэн оюутан	2021/22 оны хичээлийн жилд элссэн ба түүнээс өмнө онд элссэн оюутан
1	БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ	Инженер, технологи	170,000.0	170,000.0	162,000.0	123,000.0
2	ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ		170,000.0	170,000.0	162,000.0	123,000.0
3	МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ (МЕХАНИК ИНЖЕНЕР, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ)		170,000.0	170,000.0	162,000.0	123,000.0
4	МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		170,000.0	170,000.0	162,000.0	123,000.0
5	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ (ХҮНС, ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ, ДИЗАЙНЫ СУРГУУЛЬ)		170,000.0	170,000.0	162,000.0	123,000.0
6	ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ (ЭРЧИМ ХҮЧНИЙ ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ)		170,000.0	170,000.0	162,000.0	123,000.0
7	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ (НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ, МЕНЕЖМЕНТИЙН СУРГУУЛЬ)	Нийгмийн ухаан	166,000.0	170,000.0	157,000.0	120,000.0
8	ГАДААД ХЭЛНИЙ СУРГУУЛЬ	Хэрэглээний шинжлэх ухаан	148,000.0	148,000.0	141,000.0	108,000.0
9	ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		170,000.0	170,000.0	162,000.0	123,000.0
10	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ		148,000.0	148,000.0	141,000.0	108,000.0
ДУНДАЖ			151,950.0			



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 16


Улаанбаатар хот

Төсөв батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дугаар заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 4.3 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.2 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2025 оны төсвийн орлогыг нэгдүгээр хавсралтаар, төсвийн зарлагыг хоёрдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан төсвийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТУЛГА



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр


Дугаар 17

Улаанбаатар хот

Гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх тухай

Боловсролын ерөнхий хуулийн 34 дугаар зүйлийн 34.1 дүгээр заалт, Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5, 27.1.6, 27.1.9 дүгээр заалтууд, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2, 6.2.3 заалтууд, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 4.3 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.10 дэх заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ШУТИС-ийн Ректорын 2024 оны үр дүнгийн гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” хэмээн үнэлж, гэрээг сунгасугай.

ДАРГА  Д.ТАНТУЛГА

